

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

344. Элчин сайдыг томилох тухай Дугаар 172 1381

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

345. Журам батлах тухай Дугаар 221 1381

346. Газрын тос боловсруулах үйлдвэр
байгуулах тухай Дугаар 222 1391**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**2011 оны 08 дугаар Дугаар 172 Улаанбаатар
сарын 05-ны өдөр хот**Элчин сайдыг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 3, "Дипломат албаны тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Бүгд Найрамдах Туркменистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Очирын Очиржавыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ****Ц.ЭЛБЭГДОРЖ****МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2011 оны 7 дугаар Дугаар 221 Улаанбаатар
сарын 6-ны өдөр хот**Журам батлах тухай**

"Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2011 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 30 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ноос боловсруулах үндэсний үйлдвэрлэгчийг Засгийн газрын бондын эх үүсвэрээр дэмжих хөрөнгийг зарцуулах, хяналт тавих, тайлагнах тухай журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох тухай журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдийн бэлтгэн ноос боловсруулах үндэсний үйлдвэрт тушаасан нэгдүгээр зэргийн хонины болон тэмээний ноосонд мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Сангийн сайд С.Баярцогт нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Сангийн сайд С.Баярцогт, аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Т.БАДАМЖУНАЙ

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

Засгийн газрын 2011 оны 221 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

**НОСЛУУРАН УТАС БОЛОН ЭЦСИЙН БҮТЭЭГДЭХҮҮН
ҮЙЛДВЭРЛЭГЧ, НООС БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСНИЙ
ҮЙЛДВЭРЛЭГЧИЙГ ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН ЭХ
ҮҮСВЭРЭЭР ДЭМЖИХ ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ,
ХЯНАЛТ ТАВИХ, ТАЙЛАГНАХ ТУХАЙ ЖУРАМ**

Нэг, Нийтлэг үндэслэл

1.1. Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ноос боловсруулах үйлдвэрлэгчийг Засгийн газрын бондын эх үүсвэрээр дэмжих хөрөнгийг хөнгөлөлттэй зээл (цаашид "зээл" гэх) хэлбэрээр олгох, зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.



1.2. Зээлийг зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр бэлтгэсэн ноос, ноолуур, тэдгээрээр үйлдвэрлэсэн утсыг худалдан авч эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тоног төхөөрөмжөө шинэчлэхэд зориулж үндэсний үйлдвэр (үйлдвэр, цех, тасаг, төв зэрэг)-т олгоно.

1.3. Ноолуурын чиглэлээр нэг үйлдвэрт олгох зээлийн дээд хэмжээ 10 (арван) тэрбум, ноосны чиглэлээр 5 (таван) тэрбум төгрөгөөс ихгүй, зээлийн хугацаа 5 хүртэл жил, зээлийн хүү 7 хувиас ихгүй байна.

1.4. Зээл олгох арилжааны банкыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулсан байна.

1.5. Зээл олгох арилжааны банктай Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам гурвалсан гэрээ байгуулж, зээлийн хөрөнгийн тодорхой хувийг арилжааны банкинд урьдчилгаа болгон байршуулсан байна.

1.6. Арилжааны банк зээлийн эрсдэлийг бүрэн хариуцна.

Хоёр. Зээл олгоход тавигдах шаардлага

2.1. Дараахь шаардлагыг хангасан ноос, ноолуурын үйлдвэрт зээл олгоно:

2.1.1. хууль тогтоомжийн дагуу татвар, хураамж, төлбөр төлсөн байх;

2.1.2. ажилтнуудаа нийгмийн даатгалын шимтгэлд хамруулсан байх.

2.2. Зээл олгохдоо дараахь үзүүлэлтийг тэргүүн зэлжинд харгалзан үзнэ:

2.2.1. үйлдвэр нь хоёр буюу түүнээс дээш жижиг үйлдвэрийг ноос, ноолууран утсаар хангаж хоршин ажилладаг байх;

2.2.2. тухайн үйлдвэр нь тогтвортой үйл ажиллагаа явуулж байсан туршлага;

2.2.3. үйлдвэрийн зээлийн түүх, түүний хариуцлагын байдал;



2.2.4. үйлдвэрийн харилцах дансны гүйлгээний чадвар;

2.2.5. тухайн үйлдвэрийн брэнд бүтээгдэхүүн;

2.2.6. үйлдвэрлэлд нэвтрүүлсэн шинэ санаа, инноваци,
ноу-хау;

2.2.7. ажилчдын тоо;

2.2.8. бүтээгдэхүүнийг гадаад болон дотоодод захиалсан
гэрээ;

2.2.9. ноос, ноолууран түүхий эд худалдан авах гэрээ,
эсхүл хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдээс түүхий эд бэлтгэдэг
сүлжээ.

Гурав. Зээл олгох

3.1. Зээл авахаар үйлдвэрээс ирүүлсэн төслийг хэлэлцэн,
салбарын бодлоготой уялдуулан сонгон шалгаруулах үүргийг зохицуулах
Зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) гүйцэтгэнэ. Зөвлөл нь 9 хүний бүрэлдэхүүнтэй
байна. Ноос болон ноолуурын чиглэлээр тусдаа Зөвлөл байна. Зөвлөлийн
дарга Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн
бичгийн дарга байна.

3.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг хөнгөн үйлдвэрийн асуудал
эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Зөвлөлийн бүрэлдэхүүнд
Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголбанк,
Монголын ноос, ноолуурын холбоо, Монгол ноолуур нэгдэл, Ноосон
бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо, Монгол шиип вүүл нэгдэл (цаашид
"Мэргэжлийн холбоод, нэгдэл" гэх)-ийн төлөөлөл орсон байна.

3.3. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан
байх бөгөөд сард нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн гишүүдийн
гуравны хоёр нь оролцоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.4. Зөвлөлөөр хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон
гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, зөвлөмж гаргана. Зөвлөлийн
хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтөлж, дарга, нарийн бичгийн дарга
гарын үсэг зурж баталгаажуулна.

3.5. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам зээл авахаар ирүүлсэн төслийг хүлээн авч, судлан энэ журмын 2.1, 2.2-т заасан шаардлага, үзүүлэлтийг хангасан материалыг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангана. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж бодлогын хувьд дэмжсэн төслийг арилжааны банканд хүргүүлнэ.

3.6. Арилжааны банк нь Зөвлөлөөс дэмжиж ирүүлсэн зээл олгох тухай материалыг хүлээн авч, судлан зээл олгох шийдвэрийг ажлын 7 хоногт багтаан гаргаж, ажлын 3 хоногийн дотор үйлдвэр болон Зөвлөлийн даргад мэдэгдэн, шаардагдах мөнгөн дүнд вексель бичиж гурвалсан гэрээний дагуу Сангийн яаманд хүргүүлнэ.

3.7. Сангийн яам арилжааны банкнаас гаргасан векселийг үндэслэн зээлийн эх үүсвэрийг банкны депозит дансанд ажлын 5 хоногт багтаан шилжүүлнэ.

3.8. Арилжааны банк депозит дансанд зээлийн эх үүсвэр шилжсэнээс хойш ажлын 3 хоногт багтаан зээлийг ноос, ноолуурын үйлдвэрт олгоно.

3.9. Векселийн хугацаа болмогц нийт авсан эх үүсвэрээс зээлийн эргэн төлөлтөд төвлөрүүлсэн дүнг хасаж, үлдэгдэл эх үүсвэрийг арилжааны банк өөрийн эх үүсвэрээр хааж Сангийн яаманд үл маргах журмаар буцаан төлнө.

Дөрөв. Мэргэжлийн холбоод, нэгдлийн хүлээх үүрэг

4.1. Мэргэжлийн холбоод, нэгдэл нь нутгийн захиргааны холбогдох байгууллагатай хамтран ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн талаар мэдээллийн сан бүрдүүлнэ.

4.2. Үйлдвэр нь зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа явц, үр дүнд судалгаа хийж, тайланг хагас, бүтэн жилээр гарган Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлнэ.

4.3. Ноос, ноолуураар бэлэн бүтээгдэхүүн хийдэг сургалтын төв, хоршоо, үйлдвэрийн ноос, ноолуурын хэрэгцээ, ноос, ноолуур хүлээн



авах цэгийн байршлын талаархи мэдээллээр орон нутгийн удирдлагыг хангана.

**Тав. Зээлийн олголт, зарцуулалтад хяналт
тавих, тайлагнах**

5.1. Зээлийг зориулалтын дагуу олгох, зарцуулах үйл ажиллагаанд Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хяналт тавьж ажиллана.

5.2. Арилжааны банкнаас зээл олгосон тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудитын дүгнэлт гаргуулсан байна.

5.3. Арилжааны банк зээлийн хөрөнгийн орлого, зарлагын нэгдсэн тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор гаргаж Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1. Үйлдвэр зээлийг дор дурдсан үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно:

6.1.1. бусдад барьцаалах, баталгаа гаргах;

6.1.2. хандив өргөх;

6.1.3. ноос, ноолуурын үйлдвэрээс бусад үйлдвэрлэлийн чиглэлд зарцуулах;

6.1.4. зээлийн хөрөнгөөр худалдан авсан түүхий эдийн үнийг дотоодын зах зээлийн ханшид нөлөөлөхөөр хэт өсгөх, бууруулах.

6.2. Энэ журмын 6.1-д заасныг зөрчиж үйл ажиллагаа явуулсан ноос, ноолуурын үйлдвэртэй холбоотой асуудлыг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн зээлийг хүчингүй болгох, зээлийг хүнгийн хамт эргэн төлүүлэх, зээлд дахин хамруулахгүй байх арга хэмжээг авна.

**ХОНИНЫ НООС, ТЭМЭЭНИЙ НООС БЭЛТГЭЖ
ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРТ ТУШААСАН ХОРШООНЫ ГИШҮҮН
МАЛЧИН, МАЛ БҮХИЙ ЭТГЭЭДЭД МӨНГӨН УРАМШУУЛАЛ
ОЛГОХ ТУХАЙ ЖУРАМ***

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нэгдүгээр зэргийн буюу үргэлж-хэвийн ангиллын (цаашид "нэгдүгээр зэргийн" гэх) ноос бэлтгэж боловсруулах үндэсний үйлдвэр (үйлдвэр, цех, төв, тасаг зэрэг)-т тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Дараахь шаардлагыг хангасан гарал үүслийг баталгаажуулан үндэсний үйлдвэрт нийлүүлсэн нэгдүгээр зэргийн хонь болон тэмээний ноосны кг тутамд 2000 төгрөгийн урамшуулал олгоно:

-Ноос, ноолуур. Түүхий эд бэлтгэл. Хонины ноос. Техникийн шаардлага MNS-33-2007 стандарт;

-Ноос, ноолуур. Түүхий эд бэлтгэл. Тэмээний ноос MNS-36-2007 стандарт.

1.3. Ноос боловсруулах үндэсний үйлдвэр нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч байна.

1.4. Урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг Мал хамгаалах сангаар дамжуулан энэхүү журмын дагуу зарцуулна.

1.5. Боловсруулах үндэсний үйлдвэрт нэгдүгээр зэргийн ноос бэлтгэж тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, энэхүү журмыг тухайн нутаг дэвсгэртээ сурталчлах, энэ чиглэлээр малчдад сургалт явуулах ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар зохион байгуулна.

1.6. Боловсруулах үндэсний үйлдвэрт нэгдүгээр зэргийн ноос бэлтгэж тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн

*Тайлбар: Энэхүү журамд байгаа "хоршооны гишүүн" гэсэн тодотголыг 2013 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



урамшуулал олгох талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт, малчдад урамшуулал олгох ажилд сум, дүүргийн Засаг дарга хяналт тавина.

1.7. Улсын хэмжээнд энэхүү журмын хэрэгжилтэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хяналт тавьж ажиллана.

Хоёр. Урамшуулал олгох зарчим, журам

2.1. Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг ноос боловсруулах үйлдвэр, цех (ноос бэлтгэлийн төлөөлөгч) нь энэхүү журмын 3.4-т заасан гэрчилгээ бүхий ноосыг хүлээн авсан тухай тодорхойлолтыг хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд олгоно.

2.2. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын мал эмнэлгийн асуудал хариуцсан ажилтан нь энэхүү журмын 2.1-д заасан тодорхойлолтыг хүлээн авч, хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдийн хаяг, малын тоо (малын тоо, төрөл, нас, хүйсийг бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлтэй тулгаж), тушаасан ноосны хэмжээ, төрөл зэргийг гарган сум, дүүргийн Засаг даргаар баталгаажуулж холбогдох материалыг аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газарт жил бүрийн 9 дүгээр сарын 1-ний дотор хүргүүлнэ.

2.3. Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газар нь сум, дүүргээс ирүүлсэн материалыг бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн холбогдох мэдээлэлтэй тулган нэгтгэж, холбогдох материалыг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор Мал хамгаалах санд хүргүүлнэ.

2.4. Мал хамгаалах сан нь аймаг, нийслэл болон Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооноос ирүүлсэн материалыг харьцуулан хянаж, боловсруулах үндэсний үйлдвэрт нэгдүгээр зэргийн ноос бэлтгэж тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох асуудлыг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь уг танилцуулгыг үндэслэн урамшуулал олгох шийдвэр гаргана. Шийдвэрийг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

2.5. Энэхүү журмын 2.4-т заасан шийдвэрийг үндэслэн



урамшуулалд шаардагдах хөрөнгийг Мал хамгаалах сангаас зохих журмын дагуу орон нутагт шилжүүлнэ.

2.6. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь урамшуулал олгох тухай хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийн дагуу хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд урамшуулал олгоно.

2.7. Энэхүү журмын 3 дугаар бүлэгт заасан үүргийг биелүүлээгүй, материал хүлээн авахаар заасан хугацаанаас хоцроосон, буруу ташаа мэдээ ирүүлсэн, холбогдох материалыг бүрэн ирүүлээгүй хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд урамшуулал олгохгүй.

Гурав. Хоршооны гишүүн малчин,
мал бүхий этгээдийн үүрэг

3.1. Хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээд нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2011 оны А/74 дүгээр тушаалаар баталсан "Малыг бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тухай журам"-ын дагуу малаа бүртгэлийн нэгдсэн санд бүртгүүлсэн байна.**

3.2. Хонь болон тэмээн сүргийг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд технологит хугацаанд тогтмол хамруулсан байна.

3.3. Энэхүү журмын 1.2-т заасан стандартын шаардлагыг хангасан нэгдүгээр зэргийн ноосыг төрлөөр нь 100-500 кг-аар савлаж бэлтгэнэ.

3.4. Хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээд нь бэлтгэсэн ноосондоо тухайн сум, дүүргийн хувийн мал эмнэлэг, үржлийн нэгжээс мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ авч үйлдвэрт нийлүүлнэ.

Дөрөв. Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн
холбооны үүрэг

4.1. Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо нь үйлдвэр тус бүрээс ноос худалдан авсан тухай бүртгэл, чанар шалгагчийн дүгнэлтийг

**Тайлбар: Энэхүү журмын 3.1-д дурдсан журамд заасан үйл ажиллагаа жигдэртэл малын төрөл, тоо, нас, хүйсийг тодорхойлоход оны эцсийн мал тооллогын дансыг ашиглана.



авч нэгтгэн Мал хамгаалах санд хүргүүлнэ.

4.2. Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо нь үйлдвэр бүр худалдан авсан ноосоороо нэмэгдсэн өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа явцтай танилцаж, тайлан, мэдээг нэгтгэн улирал бүрийн дараа сарын 15-ны дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлнэ.

Тав. Урамшуулал олгох хөрөнгийг төлөвлөх

5.1. Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газар нь мал тооллогын дүн, сүргийн эргэлтэд үндэслэн харьяа нутаг дэвсгэртээ дараа жилд бэлтгэн нийлүүлэх боломжтой хонь, тэмээний ноосны хэмжээ, нутаг дэвсгэртээ байгаа үйлдвэрийн жагсаалт, тэдгээрийн хүчин чадлыг сум, дүүрэг тус бүрээр гаргаж, жил бүрийн II улиралд багтаан Мал хамгаалах санд хүргүүлнэ.

5.2. Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо нь үйлдвэр тус бүрийн дараа жил худалдан авах ноосны хэмжээг нэр, төрлөөр гаргуулж нэгтгэн жил бүрийн II улиралд багтаан Мал хамгаалах санд хүргүүлнэ.

5.3. Мал хамгаалах сан нь энэхүү журмын 5.1, 5.2-т заасан мэдээллийг харьцуулан судалж, дараа жил үйлдвэр, цехэд ноосоо тушаах хоршооны гишүүн, мал бүхий этгээдэд олгох урамшууллын хэмжээг төлөвлөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцад тусгуулах санал тавина.

Зургаа.Тайлагнах, хяналт тавих

6.1. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар малчдад урамшуулал олгосон тухай тайланг аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газарт хүргүүлнэ.

6.2. Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хөдөө аж ахуйн асуудал хариуцсан газар нь 6.1-д заасан мэдээг нэгтгэн тухайн жилийн 11 дүгээр сарын 15-ны дотор Мал хамгаалах санд хүргүүлнэ.

6.3. Мал хамгаалах сан нь тухайн онд урамшуулалд хамрагдсан хоршооны гишүүн, мал бүхий этгээдийн Сүрт,эл, :өрснийг зарцуулалтын талаархи мэдээ, тайланг дараа оны 1 дүгээр сарын 30-ны



дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлнэ.

6.4. Мал хамгаалах сан нь жил бүр урамшуулалд шаардагдах хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн тайланд дараа оны II улиралд багтаан аудит хийлгүүлнэ.

6.5. Мал хамгаалах сан нь урамшуулал олгох асуудлыг төлөвлөх, олгох асуудалтай холбоотой материал, мэдээлэл, тайланг архивын нэгж болгон хадгална.

Долоо. Хариуцлага

7.1. Үйлдвэр хуурамч мэдээлэл гаргаж өгснөөс үүссэн хохирлыг уг үйлдвэр өөрөө бүрэн хариуцна.

7.2. Хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдийн нийлүүлсэн ноосны хэмжээ, чанар, ангиллын талаар буруу ташаа мэдээ ирүүлсэн, тодорхойлолт өгсөн боловсруулах үйлдвэр, цехийн гаргасан бусад тодорхойлолтыг хүлээн авахгүй бөгөөд зээл болон бусад дэмжлэгийг дахин олгохгүй. Гарсан хохирлыг бүрэн төлүүлнэ.

7.3. Хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд ноос бэлтгэсэн тухай хуурамч гэрчилгээ олгосон хувийн мал эмнэлэг, үржлийн нэгжийн үйл ажиллагаа явуулах эрхийг нь хасах саналыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гарсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 7 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 222

Улаанбаатар
хот

Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, 6 дахь заалт, Концессын тухай хуулийн 6.1.1, 10.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн Чойбалсан хотод газрын тос боловсруулах



"Дорнод газрын тос" төрийн өмчийн оролцоотой компани байгуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

2. "Концессын зүйлийн жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 198 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д дор дурдсан агуулга бүхий 11 дүгээр бүлгийг нэмсүгэй:

Арван нэг. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслүүд						
125	Газрын тос боловсруулах үйлдвэр	Газрын тосны бүтээгдэхүүнээр бус нутгийн дотоодын хэрэгцээг хангах	Барих-өмчлөх-ашиглах	Газрын тос боловсруулах үйлдвэр барих	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах

3. "Дорнод газрын тос" компанийн хувийг эзэмших аж ахуйн нэгжийг зохих журмын дагуу сонгон шалгаруулж, компанийн дүрмийг боловсруулж хууль тогтоомжийн дагуу батлуулах арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ЭРДЭС БАЯЛАГ,
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**

Д.ЗОРИГТ

Хаяг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци,
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turin_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвтээний хуудас 0.75

Индекс: 14003



МОНГОЛ УЛСЫН
ХАНОГ ТУТМАН ХЭВЛЭЛ
НЫ 07 ДУГААР САРЫН 05
№33 /702/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН
ХАНОГ ТУТМАН ХЭВЛЭЛ
НЫ 07 ДУГААР САРЫН 05
№33 /702/

381


МОНГОЛ УЛСЫН
ХАНОГ ТУТМАН ХЭВЛЭЛ
НЫ 07 ДУГААР САРЫН 05
№33 /702/

381

**Элчин сайдыг томилох
тухай**

Журам батлах тухай





Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсгит хэвлэв,
Утас 329487